



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 5 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СЭА-2026/002/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: “Пийк Ом Аудит” ХХК Захирал: Б.Жаргалсайхан Утас: 99862066 Цахим хаяг: peakomauditllc@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СҮХБААТАР СУМЫН 5 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
С.СЭЛЭНГЭ ТАНАА

2026.02.25 № СЭА-2026/002/НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар сумын 5 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлох хэсэг

Тус цэцэрлэг нь Сүхбаатар сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 16,218.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 8,366.6 мянган төгрөгийн тавилга эд хогшил зэрэг нийт 24,585.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Сүхбаатар сумын 5 дугаар цэцэрлэг нь 2025 оны "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан 2 зорилго, 10 зорилт, 86 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 92.3 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	102,310,182.11	32,152,308.87
312	Банканд байгаа бэлэн мөнгө		102,310,182.11	32,152,308.87
3121	Төгрөг		102,310,182.11	32,152,308.87
31211	Төрийн сангийн харилцах		102,310,182.11	32,152,308.87
33	АВЛАГА		29,642.27	4,124,823.38
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		29,642.27	29,642.27
3351	Байгууллагаас авах авлага		0.00	4,095,181.11
35	БАРАА МАТЕРИАЛ	6	113,936,422.00	110,924,664.50
354	Хангамжийн материал		113,936,422.00	110,924,664.50
3541	Бичиг хэргийн материал		436,200.00	516,850.00
3542	Аж ахуйн материал		3,571,700.00	3,464,300.00
3545	Барилгын материалын		285,000.00	285,000.00
3546	Хүнсний материал		3,498,727.00	1,580,719.50
3547	Бусад хангамжийн материал		106,144,795.00	105,077,795.00
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		216,276,246.38	147,201,796.75
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	1,927,771,099.01	1,880,365,845.26
392	Биет хөрөнгө		1,922,090,016.01	1,874,749,845.26
39201	Барилга, байгууламж, орон сууц		2,069,299,344.00	2,069,299,344.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		-195,497,507.60	-229,985,829.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл			
39204	Хуримтлагдсан элэгдэл			
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		89,806,587.00	75,297,085.00
39206	Хуримтлагдсан элэгдэл		-56,836,455.59	-51,223,518.89
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		55,668,340.00	48,005,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл		-51,881,939.84	-45,513,433.33
39214	Бусад үндсэн хөрөнгө		26,611,496.00	26,611,496.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		-15,079,847.96	-17,740,997.60
39217	Ном			
393	Биет бус хөрөнгө		5,681,083.00	5,616,000.00
39301	Программ хангамж		390,500.00	390,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		-325,417.00	-390,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө		5,616,000.00	5,616,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,927,771,099.01	1,880,365,845.26
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,144,047,345.39	2,027,567,642.01
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9	0.00	299,000.00
413	Өглөг		0.00	299,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг		0.00	299,000.00
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		0.00	299,000.00
51	Засгийн газрын хувь оролцоо		2,144,047,345.39	2,027,268,642.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан			
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө			
512	Хуримтлагдсан үр дүн		2,144,047,345.39	2,027,268,642.01
5121	Өмнөх үеийн үр дүн		2,144,047,345.39	2,144,047,345.39
5122	Тайлант үеийн үр дүн			-116,778,703.38
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү			
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,144,047,345.39	2,027,268,642.01
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		2,144,047,345.39	2,027,567,642.01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	715,469,300.00	817,246,404.34
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	626,555,300.00	726,286,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	626,555,300.00	726,286,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	88,914,000.00	90,960,104.34
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	88,914,000.00	90,960,104.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51,562,255.00	15,660,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	51,562,255.00	15,660,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1E+42	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,000.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	9,978,405.00	
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	41,583,850.00	15,660,900.00
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	767,121,555.00	832,907,304.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	803,878,003.06	949,686,007.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	803,878,003.06	949,686,007.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	496,952,852.64	628,659,749.94
210101	Үндсэн цалин	346,721,391.08	403,817,116.23
210102	Нэмэгдэл	132,794,886.56	184,375,120.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,474,000.00	21,270,000.00
210104	Урамшуулал	13,962,575.00	19,197,513.03
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,654,715.08	79,156,609.31
210201	Тэтгэврийн даатгал	43,450,696.37	54,539,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,004,500.75	6,347,794.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,429,650.48	3,087,463.81
210204	Ажилгүйдлийн даатгал	2,309,972.26	2,974,226.50
210205	Эрүүл мэндийн даатгал	9,459,895.22	12,207,924.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,513,700.00	80,992,204.34
210301	Гэрэл, цахилгаан	6,043,736.03	8,229,641.94
210302	Түлш, халаалт	52,088,373.97	58,731,622.40
210303	Цэвэр, бохир ус	13,381,590.00	14,030,940.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,491,724.54	2,317,000.00
210402	Тээвэр, шатахуун		
210408	Бараа материал ақталсны зардал	21,491,724.54	2,317,000.00
2105	Нормативт зардал	59,231,096.32	65,261,983.00
210502	Хоол, хүнс	59,231,096.32	65,261,983.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,994,900.00	9,967,900.00
210604	Урсгал засвар	11,994,900.00	9,967,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,046,564.38	1,675,857.38

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,046,564.38	1,675,857.38
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,992,450.10	81,654,703.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,061,286.38	25,517,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,560,930.00	6,318,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,370,233.72	49,818,653.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
2132	Бусад урсгал шилжүүлэг		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	803,878,003.06	949,686,007.72
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-36,756,448.06	-116,778,703.38
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-36,756,448.06	-116,778,703.38

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	715,559,300.00	817,246,404.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	90,000.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	90,000.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	90,000.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	715,469,300.00	817,246,404.34
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	626,555,300.00	726,286,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	626,555,300.00	726,286,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	88,914,000.00	90,960,104.34
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	88,914,000.00	90,960,104.34
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	731,425,774.75	884,990,877.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ		
		731,425,774.75	884,990,877.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		
		731,425,774.75	884,990,877.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	496,957,555.34	632,754,931.05
210101	Үндсэн цалин	346,726,093.78	407,215,771.45
210102	Нэмэгдэл	132,794,886.56	184,658,571.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,474,000.00	21,270,000.00
210104	Урамшуулал	13,962,575.00	19,610,588.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,679,654.65	79,156,609.31

210201	Тэтгэврийн даатгал	43,475,635.94	54,539,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,004,500.75	6,347,794.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,429,650.48	3,087,463.81
210204	Ажилгүйдлийн даатгал	2,309,972.26	2,974,226.50
210205	Эрүүл мэндийн даатгал	9,459,895.22	12,207,924.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,513,700.00	80,992,204.34
210301	Гэрэл, цахилгаан	6,043,736.03	8,229,641.94
210302	Түлш, халаалт	52,088,373.97	58,731,622.40
210303	Цэвэр, бохир ус	13,381,590.00	14,030,940.00
2105	Нормативт зардал	60,948,534.00	63,343,975.50
210502	Хоол, хүнс	60,948,534.00	63,343,975.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,400,300.00	9,967,900.00
210604	Урсгал засвар	17,400,300.00	9,967,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,046,564.38	1,742,607.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,046,564.38	1,742,607.38
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,879,466.38	17,032,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,233,536.38	10,713,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,645,930.00	6,318,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
2132	Бусад урсгал шилжүүлэг		
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-15,866,474.75	-67,744,473.24
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		2,413,400.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		2,413,400.00
	Дотоод эх үүсвэрээр		2,413,400.00
222001	Тоног төхөөрөмж		
223001	Бусад хөрөнгө		2,413,400.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		-2,413,400.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-15,866,474.75	-70,157,873.24
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	118,176,656.86	102,310,182.11
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	102,310,182.11	32,152,308.87

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			2,144,047,345.39	2,144,047,345.39
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			2,144,047,345.39	2,144,047,345.39
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			-116,778,703.38	-116,778,703.38
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			2,027,268,642.01	2,027,268,642.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	930,959,800.00	817,246,404.34	95,442,800.00	87.8
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	821,729,100.00	726,286,300.00	95,442,800.00	88.4
131001	Улсын төсвөөс санхүүжих	821,729,100.00	726,286,300.00	95,442,800.00	88.4
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих				
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	109,230,700.00	90,960,104.34	18,270,595.66	83.3
132001	Орон нутгийн төсвөөс	109,230,700.00	90,960,104.34	18,270,595.66	83.3
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих				
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих				
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	930,959,800.00	817,246,404.34	95,442,800.00	87.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	930,959,800.00	887,404,277.57	43,555,522.43	95.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	930,959,800.00	887,404,277.57	43,555,522.43	97.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	647,164,700.00	632,754,931.05	14,409,768.95	93.2
210101	Үндсэн цалин	436,807,800.00	407,215,771.45	29,592,028.55	93.2
210102	Нэмэгдэл	198,193,400.00	184,658,571.17	13,534,828.83	93.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт		21,270,000.00	-21,270,000.00	
210104	Урамшуулал	12,163,500.00	19,610,588.43	-7,447,088.43	161.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,425,700.00	79,156,609.31	1,269,090.69	98.4
210201	Тэтгэврийн даатгал	54,539,200.00	54,539,200.00	0.00	100

210202	Тэтгэмжийн даатгал	6,471,600.00	6,347,794.82	123,805.18	98.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,235,800.00	3,087,463.81	148,336.19	95.4
210204	Ажилгүйдлийн даатгал	3,235,800.00	2,974,226.50	261,573.50	91.9
210205	Эрүүл мэндийн даатгал	12,943,300.00	12,207,924.18	735,375.82	94.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,230,700.00	80,992,204.34	18,238,495.66	81.6
210301	Гэрэл, цахилгаан	19,839,600.00	8,229,641.94	11,609,958.06	41.5
210302	Түлш, халаалт	60,318,700.00	58,731,622.40	1,587,077.60	97.4
210303	Цэвэр, бохир ус	19,072,400.00	14,030,940.00	5,041,460.00	73.6
2105	Нормативт зардал	69,923,000.00	63,343,975.50	6,579,024.50	90.6
210502	Хоол, хүнс	69,923,000.00	63,343,975.50	6,579,024.50	90.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	9,967,900.00	32,100.00	99.7
210604	Урсгал засвар	10,000,000.00	9,967,900.00	32,100.00	99.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,420,300.00	1,742,607.37	1,677,692.63	50.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж			0.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,420,300.00	1,742,607.37	1,677,692.63	50.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,795,400.00	19,446,050.00	1,349,350.00	93.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,476,500.00	13,127,250.00	1,349,250.00	90.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,318,900.00	6,318,800.00	100.00	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00	0.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	0.00	0.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал			0.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал				
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	930,959,800.00	887,404,277.57	43,555,522.43	95.3
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		102,310,182.11	-	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		32,152,308.87	-32,152,308.87	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
3	Төсвийн байгууллага	1	1		100
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	26	26	0	100
6	Удирдах ажилтан	1	1	0	100
7	Гүйцэтгэх ажилтан	15	15	0	100
8	Үйлчлэх ажилтан	10	10	0	100
12	Төрийн өмчит ЕБС	158.00	148.00	10	98.6
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26	26	0	100
28	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	14	14	0	100
33	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12	12	0	100

Гуравдугаар. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 36,552.1 мянган төгрөгийн зөрчил илэрч, 4,095.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 32,456.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 4,095.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 8,038.8 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

1. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 4,095.2 мянган төгрөгийн ХХОАТ-ыг давхардуулан шилжүүлж авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1 Илрүүлэлт: Тус байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд 32,456.9 мянган төгрөгийн анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй, 78 ширхэг үндсэн хөрөнгийг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх саналыг хүргүүлээгүй байна,

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх саналыг хүргүүлж байх зөвлөмж хүргүүлээ.

Дөрөвдүгээр. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлага үүсгэсэн	1	4,095.2			1	4,095.2						
Тус байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй, 78 ширхэг үндсэн хөрөнгийг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх саналыг хургүүлээгүй	1	32,456.9					1	32,456.9				
Дүн	2	36,552.1			1	4,095.2	1	32,456.9				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			